



ХҮЛЭМЖИЙН СУДАЛГАА

Тайлан



Улаанбаатар
2024 оны 6-р сар

МЭДЭГДЭЛ

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-аар дамжуулан Америкийн ард түмний өгөөмөр тусламжаар энэхүү судалгааг гүйцэтгэх боломжтой болсон. Судалгааны агуулга, тайлан дүгнэлт нь АНУ-ын Засгийн газар эсвэл USAID-ын байр суурийг илэрхийлэхгүй болно. Хөгжлийн Шийдэл ТББ нь судалгааны ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан бөгөөд судалгааны үр дүнгээс үүдэх аливаа хариуцлагыг хүлээхгүй.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ӨНЭЗС	Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЭЗСЭШХ	Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн

Гарчиг

1. ОРШИЛ	6
2. ДОТООДЫН ХҮЛЭМЖИЙН АЖ АХУЙ БА ХҮНСНИЙ НАРИЙН НОГООНЫ НИЙЛҮҮЛЭЛТ	9
2.1. Хүлэмжийн аж ахуй эрхлэлт	9
2.2. Дотоодын хүлэмжийн хүнсний ногооны нийлүүлэлт	12
3. ИМПОРТЫН ӨРСӨЛДӨӨН	16
3.1. Хүлэмжийн ногооны импорт	16
3.2. Дотоодын тариалалт ба импортын харьцаа	18
4. ХҮЛЭМЖИЙН НОГООНЫ ДОТООДЫН ЭРЭЛТ	20
4.1. Айл өрхүүдийн хүлэмжийн ногооны хэрэглээ	20
4.2. Нийтийн хоолны үйлдвэрлэл дэх хүлэмжийн ногооны эрэлт	25
5. ХҮЛЭМЖИЙН НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ БА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА	28
5.1. Хүнсний нарийн ногооны хэрэглээ ба нийлүүлэлт	28
5.2. Үнийн шинжилгээ	29
5.1.1. Үйлдвэрлэгчийн үнэ, үйлдвэрлэгчийн нэмэгдэл өртөг	29
5.1.2. Импортын үнэ	31
5.1.3. Хэрэглэгчийн үнэ	33
6. ХҮЛЭМЖИЙН АЖ АХУЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖ	34
6.1. Хүлэмжийн аж ахуйн эрхлэгчдийн нөхцөл байдал	34
6.2. Хүлэмжийн аж ахуйн санхүүгийн загвар	35
7. ДҮГНЭЛТ	39
АШИГЛАСАН МАТЕРИАЛ, НОМ ЗҮЙ	41

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хүлэмжийн аж ахуй эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгжийн тоо ба хүлэмжийн талбай	9
Хүснэгт 2. Хүлэмжийн талбай хүлэмжийн төрлөөр, м ² , 2023 он	10
Хүснэгт 3. Хүнсний ногоо тариалсан талбайн хэмжээ, га, 2023 он	11
Хүснэгт 4. Хүнсний ногооны ургац, тонн, 2023 он	13
Хүснэгт 5. Хүлэмжийн нарийн ногооны ургацын хэмжээ, тонн, 2023 он	15
Хүснэгт 6. Хүнсний ногооны хангамж, импорт ба дотоодын тариалалт, тонн, 2023 он	18
Хүснэгт 7. Өрхүүдийн хүнсний ногооны нийт хэрэглээ (тонн), 2022 он, аймгаар	23
Хүснэгт 8. Өрхүүдийн хүнсний ногооны жилийн худалдан авалт (сая төгрөг), 2022 он, аймгаар	24
Хүснэгт 9. Өрхүүдийн хүнсний ногооны сарын дундаж худалдан авалт (төгрөг), 2022 он, орлогын бүлгээр	25
Хүснэгт 10. Зарим хоолны газрын хүнсний ногооны 7 хоногийн дундаж хэрэглээ, кг	26
Хүснэгт 11. Хүнсний ногооны үйлдвэрлэгчийн голч (медиан) үнэ, төгрөг/кг	29
Хүснэгт 12. Хүлэмж, агуулах ашиглалт	31
Хүснэгт 13. Хүнсний ногооны үйлдвэрлэгчийн ба импортлогчийн дундаж үнэ (төгрөг/кг), 2023	33
Хүснэгт 14. Хэрэглэгчдийн төлсөн голч үнэ, төгрөг/кг	33
Хүснэгт 15. Хүнсний ногооны үйлдвэрлэгчийн ба хэрэглэгчийн үнийн зөрүү, төгрөг, 2023 он	33

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хүнсний нарийн ногооны нийт ургац, тонн	13
Зураг 2. Хүнсний ногооны импорт, тонн	16
Зураг 3. Хүнсний ногооны импорт, сая төгрөг	16
Зураг 4. Хүнсний нарийн ногооны импорт, тонн, улирлаар	17
Зураг 5. Хүнсний нарийн ногооны импорт, сая төгрөг, улирлаар	18
Зураг 6. Хүлэмжийн ногооны дотоодын тариалалт ба импортын эзлэх хувь, 2023 он	19
Зураг 7. Нийт өрхүүдийн нарийн ногооны жилийн хэрэглээ, тонн	20
Зураг 8. Нийт өрхүүдийн нарийн ногооны жилийн хэрэглээний дүн, тэрбум төг	21
Зураг 9. Өрхийн нарийн ногооны сарын хэрэглээ (кг), улирлаар	21
Зураг 10. Хүнсний ногооны үнэ (төгрөг / кг), улирлаар	22
Зураг 11. Хүнсний нийт нарийн ногооны нийлүүлэлт ба хэрэглээний харьцаа, 2022 он	28
Зураг 12. Хүнсний ногооны нийлүүлэлт ба хэрэглээний харьцаа, 2022 он, ногооны төрлөөр	29
Зураг 13. Өрхийн аж ахуйд хүнсний ногоо тариалах зардлын бүтэц, 2022 он	30
Зураг 14. Импортын хүнсний ногооны дундаж үнэ, төгрөг/кг	32

1.ОРШИЛ



Хөдөө аж ахуй (ХАА)-н салбарыг дэмжих олон улсын байгууллагын төслүүдийн тайланд хүлэмжийн аж ахуйн талаар зарим хэсэгчилсэн судалгаа хийгдсэн байдаг (SECiM, 2018; Хөгжлийн шийдэл, 2023; ЭЗСЭШХ, 2019). Энэ чиглэлээр тариаланчдад зориулсан сүүлийн үеийн дэлгэрэнгүй материал бол Германы хамтын ажиллагааны бэлтгэсэн өвлийн нарлаг хүлэмжийн бизнес төлөвлөгөө боловсруулах гарын авлага (GIZ, 2023a) болон хүлэмж байгуулах технологийн гарын авлага (GIZ, 2023b) юм. Эдгээрээс өөр хүлэмжийн аж ахуй эрхлэлт, хүлэмжийн ногооны зах зээлийн талаарх дэлгэрэнгүй судалгаа манай улсад ховор байна.

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны ажил нь хүлэмжийн ногооны зах зээлийн динамикийг ойлгох, хүлэмжийн салбарын тогтвортой өсөлтийг хангахад шаардлагатай хүчин зүйлсийг тодорхойлж, дотоодын хүлэмжийн хүчин чадал, нийлүүлэлтийн түвшинд дүн шинжилгээ хийх зорилготой.

Энэ хүрээнд дараах зорилтуудын дагуу судалгааг гүйцэтгэв. Үүнд:

- Дотоодын хүлэмжийн аж ахуйн нийлүүлэлтийн түвшнийг тогтоох
- Хүлэмжийн ногооны хангамжид импортын эзлэх хувийг тооцох
- Хүлэмжийн аж ахуйн эрэлтийн түвшнийг тогтоох
- Эрэлт, нийлүүлэлтийн харьцаа, зах зээл дээрх үнийн хэлбэлзлийн асуудал
- Хүлэмжийн аж ахуйн эрхлэгчдийн өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй асуудал
- Хүлэмжийн аж ахуйн эдийн засгийн үр өгөөж, ашигт ажиллагаа, санхүүгийн жишиг тооцоолол гаргах

Судалгааны аргазүй

Энэхүү судалгаанд дараах үндсэн арга зүйг ашигласан. Үүнд:

- Захиргааны тоон мэдээллийн шинжилгээ. ХХААХҮЯ, нийслэл ба аймгуудын Хүнс, хөдөө ахуйн газруудаас дотоодын дөрвөн улирлын болон зуны хүлэмжийн нийт тоо, ангилал, хүчин чадал, үйлдвэрлэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулж, хүлэмжийн ногооны дотоодын үйлдвэрлэлийн нийлүүлэлтийн дүр зургийг хүлэмжийн ногооны нэр төрөл тус бүрээр тодорхойлохыг зорив.
- Хоёрдогч мэдээллийн шинжилгээ. Үндэсний статистикийн хорооны

- мэдээллийн сан дахь хүлэмжийн аж ахуй, хүлэмжид тариалдаг хүнсний ногооны статистик мэдээлэл, олон улсын байгууллага, хүнсний ногооны хангамжийн чиглэлээр хийсэн сүүлийн үеийн судалгаа, тайлан, мэдээлэлд тойм шинжилгээ хийв.
- Гүнзгийрүүлсэн ярилцлага. Дотоодын хүлэмжийн ногоо тариалалтын талаар чанарын нэмэлт мэдээллийг бүрдүүлэх, захиргааны мэдээллийн бодит байдлыг хянаж нягтлахын тулд хүлэмжийн ногоо тариалдаг 15 аж ахуйн нэгж, тариаланчидтай гүнзгийрүүлсэн ярилцлага хийж нэмэлт мэдээлэл цуглуулав.
 - Гаалийн статистик. Гаалийн ерөнхий газрын статистик мэдээллийг ашиглан дотоодын хүлэмжийн ногоотой өрсөлдөх импортын барааны нийлүүлэлтийг тодорхойлох судалгаа хийв. Хүлэмжийн ногооны дотоодын үйлдвэрлэл болон импортын хангамж нийлээд дотоод дахь хүлэмжийн ногооны нийлүүлэлтийг бүрдүүлнэ гэж үзэв.
 - Эрэлтийн шинжилгээ. ҮСХ-ны Өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгааны анхдагч тоон мэдээлэлд үндэслэн хүлэмжийн ногооны эрэлт хэрэглээний талаар дэлгэрэнгүй шинжилгээ хийв.
 - Эрэлтийн нэмэлт шинжилгээ. Дотоодын хүлэмжийн ногооны эрэлтийг тодорхойлох нэмэлт мэдээлэл бүрдүүлэхийн тулд хүлэмжийн ногоо худалдаалдаг хамгийн том зах, супермаркетууд, хоолны сүлжээ ресторан 15 аж ахуйн нэгжээс асуулгын аргаар нэмэлт мэдээлэл цуглуулна.
 - Хүлэмжийн ногооны нийлүүлэлт, эрэлтийн мэдээлэлд үндэслэн зах зээлийн тэнцвэрийн шинжилгээ хийсэн. Энэ судалгаанд хүлэмжид тариалдаг хүнсний ногооны тухайн нэр төрлийн зах зээлийн нийлүүлэлт ба эрэлт дараах тэгшитгэлээр тодорхойлогдоно гэж үзлээ.

$$\text{Нийлүүлэлт}_i = \text{Дотоодын тариалалт}_i + \text{Импорт}_i = \text{Эрэлт}_i$$

Энд, i нь хүлэмжид тариалдаг хүнсний ногооны нэр төрөл. Энэ судалгаанд хүлэмжид тариалдаг хүнсний ногоог дараах 4 нэр төрлөөр ангилсан. Үүнд улаан лооль, өргөст хэмх, чинжүү, навчит ногоо (салатны навч гэх мэт).

Хүлэмжид тариалдаг хүнсний ногооны нэр төрөл бүрийн нийлүүлэлт нь дотоодын тариалалт ба импортын нийлүүлэлтээс бүрдэнэ. Энэхүү нийлүүлэлт нь дотоодын хэрэгцээг хангах буюу эрэлттэй дүйж байх ёстой. Энэ судалгаанд бид хүлэмжид тариалдаг нэр төрөл бүрээрх нийлүүлэлтийг дотоодын тариалалт ба импортын дэлгэрэнгүй мэдээллийг ашиглан ойролцоогоор тооцож, нэр төрөл бүрийн хувьд дотоодын тариалалт ба импортын харьцаа ямар байгааг тооцсон. Мөн дотоодын тариалалтын хувьд хүлэмжийн аж ахуйн нэгж талбайгаас авах ургац буюу бүтээмжийг тодруулж авч үзсэн.

Хүлэмжийн ногооны эрэлт хэрэгцээ нь хүн амын хүнсний хэрэглээний тоон мэдээллээс гарна. Энэ хэрэглээ нь дараах хоёр төрлийн хэрэглээнээс бүрдэнэ.

1. Өрхүүдийн худалдан авч, эсвэл өөрийн аж ахуйгаас хүнсэндээ үнэгүй хэрэглэсэн хүлэмжийн ногооны хэрэглээ. Үүнийг ҮСХ-ны улс, аймгийн хэмжээнд хүн амыг төлөөлөх чадвартай Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаан дахь өрхүүдийн хэрэглээний дэлгэрэнгүй тоон мэдээллээс тодруулахыг зорьсон. Энэ мэдээллээс хүлэмжийн ногооны хэрэглээг сар, улирлаар, аймгаар, өрхийн янз бүрийн бүлгээр харьцуулан судлах боломжтой.
2. Өрхийн гишүүдийн гадуур хооллохдоо хэрэглэсэн хүлэмжийн ногооны хэрэглээ. Үүнийг нарийвчлан тооцох тоон мэдээлэл хангалтгүй тул нийтийн хоолны салбарын төлөөллөөс мэдээлэл цуглуулж, цайны газар, ресторанууд, сүлжээ дэлгүүрээр борлуулдаг, хүлэмжийн ногоо ашиглан бэлтгэсэн эцсийн бүтээгдэхүүн болох ногооны зууш, хоолонд ашигладаг хүлэмжийн ногооны хэмжээг ойролцоогоор тооцохыг зорьсон.

2. ДОТООДЫН ХҮЛЭМЖИЙН АЖ АХУЙ БА ХҮНСНИЙ НАРИЙН НОГООНЫ НИЙЛҮҮЛЭЛТ



2.1. Хүлэмжийн аж ахуй эрхлэлт

2022 оны байдлаар улсын хэмжээнд 880 мянган метр квадрат зуны хүлэмж, 320 мянган метр квадрат өвлийн хүлэмж ашиглаж байжээ¹. Нийслэл болон 17 аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас бэлтгэн ирүүлсэн хүлэмжийн аж ахуйн бүртгэл мэдээллээр, 2023 оны эцсийн байдлаар эдгээр аймаг болон нийслэлд нийт 4,539 иргэн, 415 аж ахуйн нэгж (ААН) хүлэмжийн аж ахуй эрхэлж байна. Иргэдийн хүлэмжийн нийт талбай 717 мянган метр квадрат бол ААН-үүдийн хүлэмжийн талбай 891 мянган метр квадрат байна. Нийслэл болон Төв, Сэлэнгэ аймагт иргэдийн тариалдаг хүлэмжийн талбай хамгийн их байгаа бол ААН-үүдийн хувьд хүлэмжийн нийт талбайн 88.9% нь нийслэлд ногдож байна.

Хүснэгт 1. Хүлэмжийн аж ахуй эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгжийн тоо ба хүлэмжийн талбай

Аймаг	Иргэний тоо	Нийт талбай, м ²	Аж ахуйн нэгжийн тоо	Нийт талбай, м ²
Архангай	127	15,217	0	0
Баянхонгор	18	4,523	2	14,380
Баян-Өлгий	166	5,963	64	1,360
Булган	216	13,390	1	318
Говь-Алтай	2	4,500	0	0
Говьсүмбэр	17	4,588	6	3,344
Дархан-Уул	84	12,038	9	21,280
Дорноговь	338	74,263	-	-
Дорнод	828	28,832	-	-
Дундговь	123	13,919	18	4,524
Завхан	60	5,132	5	1,760
Өвөрхангай	229	12,813	54	17,388
Сүхбаатар	359	74,566	-	-
Сэлэнгэ	691	104,232	32	9,598
Төв	291	111,445	109	18,019
Хөвсгөл	256	17,057	7	3,582

¹ УИХ-ын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36-р тогтоолд дурдсан.

Хэнтий	290	14,520	20	3,224
Улаанбаатар	444	200,310	88	792,129
Нийт	4,539	717,308	415	890,906

Эх сурвалж: Аймаг, нийслэлийн ХХАА газруудын бэлтгэсэн статистик мэдээлэл

Гэхдээ энэ статистикт Орхон, Ховд гэх мэт хүнсний ногоо идэвхтэй тариалдаг аймгуудын мэдээлэл ороогүй, зарим аймгийн (Дорноговь, Дорнод гэх мэт) мэдээлэл дутуу ирснийг тэмдэглэх нь зүйтэй.

Тариалалт хийж байгаа хүлэмжийн талбайг төрлөөр нь Хүснэгт 2-т харуулав. Эндээс харахад, тариалалт хийж буй хүлэмжийн дийлэнх нь (70.6%) нь нийлэг хальсан буюу зуны хүлэмж байна. Харин өвөл ашиглах боломжтой нарлаг хүлэмж 14.1%, шилэн хүлэмж 15.3%-ийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 2. Хүлэмжийн талбай хүлэмжийн төрлөөр, м², 2023 он

№	Аймаг нийслэл	Нарлаг	Шилэн	Нийлэг хальсан
1	Архангай	5,061	0	10,156
2	Баянхонгор	480	8,320	10,103
3	Баян-Өлгий	1,000	200	6,799
4	Булган	1,260	0	0
5	Говь-Алтай	0	0	4,500
6	Говьсүмбэр	1,430	0	5,094
7	Дархан-Уул	14,960	1,464	13,594
8	Дундговь	2,080	200	13,919
9	Дорноговь	870	0	0
10	Дорнод	0	500	18,354
11	Завхан	0	600	6,157
12	Өвөрхангай	3,065	490	26,945
13	Сүхбаатар	0	0	74,566
14	Сэлэнгэ	6,820	784	106,226
15	Төв	59,078	23,654	149,732
16	Ховд	1,890	0	6,758
17	Хөвсгөл	150	4,640	15,849
18	Хэнтий	2,207	0	15,130
19	Улаанбаатар	47,763	119,772	256,098
НИЙТ		148,114	160,624	739,980

Эх сурвалж: Аймгуудын ХХААГ-ын бэлтгэсэн статистик мэдээлэл

Аймгуудаар харьцуулбал хүлэмжийн төрөл янз бүрийн харьцаатай байна. Тухайлбал, Булган, Дорноговь аймгуудын бүх хүлэмж нь нарлаг хүлэмж бол

Говь-Алтай, Сүхбаатар аймгуудын бүх хүлэмж нийлэг хальсан хүлэмж байна. Үүнээс гадна, Архангай, Говьсүмбэр, Ховд, Хэнтий аймагт шилэн хүлэмж огт ашигладаггүй байна. Хамгийн их хүлэмжийн талбай бүхий Улаанбаатарт нийт талбайн 60.4% нь нийлэг хальсан, 28.3% нь шилэн, 11.3% нь нарлаг хүлэмж байгаа бол хүлэмжийн талбайгаар нийслэлийн дараа орох Төв аймагт нийт талбайн 64.4% нь нийлэг хальсан, 25.4% нь шилэн, 10.2% нь нарлаг, Сэлэнгэ аймагт нийт талбайнх нь 93.3% нь нийлэг хальсан, 6.0% нь шилэн, 1.6% нь нарлаг хүлэмж байгаа юм.

Хүлэмжийн талбайн талаарх дээрх мэдээллийг ҮСХ-ны хүнсний нарийн ногооны тариалсан талбайн мэдээлэлтэй харьцуулах боломжтой. Хүснэгт 3-д ҮСХ-ны статистикийн мэдээллийн сангаас хүлэмжид тариалдаг хүнсний ногооны төрлүүд болох өргөст хэмх, улаан лооль, чинжүүний тариалсан талбайн хэмжээг 2023 оны байдлаар аймаг, нийслэлээр харуулав. Харин уг статистикт навчит ногооны тариалсан талбайн мэдээлэл байгаагүй.

Улсын хэмжээнд өргөст хэмх, улаан лооль, чинжүүг нийт 998.2 га талбайд тариалж байна. Энэ нь нийт хүнсний ногоо тариалсан талбайн 6.3% болно. Үүнээс дийлэнх буюу 736.8 га талбайд өргөст хэмх, 217.5 га талбайд улаан лооль, 44.1 га талбайд чинжүү тариалж байна.

Хүснэгт 3. Хүнсний ногоо тариалсан талбайн хэмжээ, га, 2023 он

Аймаг	Өргөст хэмх	Улаан лооль	Чинжүү	Гурван төрлийн нийлбэр	Хүнсний ногоо -Бүгд	Нарийн ногооны талбайн эзлэх хувь
Архангай	3.1	1.5	0.2	4.8	125.4	3.8%
Баянхонгор	6.7	5.7	1.4	13.8	127.6	10.8%
Баян-Өлгий	14.0	8.5	0.0	22.5	157.5	14.3%
Булган	9.5	6.6	3.1	19.2	290.6	6.6%
Говь-Алтай	7.4	3.0	1.0	11.3	71.6	15.8%
Говьсүмбэр	1.5	1.4	0.4	3.3	33.7	9.9%
Дархан-Уул	117.1	2.8	0.7	120.7	1,641.4	7.4%
Дундговь	2.7	1.9	0.9	5.5	23.1	23.6%
Дорноговь	24.9	4.9	1.1	30.9	95.2	32.4%
Дорнод	18.6	15.7	3.3	37.5	190.0	19.8%
Завхан	3.4	1.4	0.3	5.1	182.8	2.8%
Өвөрхангай	8.5	10.8	2.0	21.3	303.3	7.0%
Өмнөговь	9.7	15.6	2.5	27.7	94.7	29.3%
Орхон	3.5	1.6	0.3	5.4	455.3	1.2%
Сүхбаатар	4.3	2.9	1.6	8.7	68.2	12.8%
Сэлэнгэ	280.1	32.7	15.4	328.2	4,910.9	6.7%

Төв	13.1	7.1	1.6	21.8	3,349.7	0.6%
Увс	13.7	11.2	0.0	24.9	497.7	5.0%
Ховд	124.9	52.9	1.1	178.9	2,135.9	8.4%
Хөвсгөл	22.6	11.1	2.9	36.6	340.2	10.8%
Хэнтий	10.0	5.6	1.3	16.8	295.3	5.7%
Улаанбаатар	37.5	12.7	3.1	53.3	399.7	13.3%
Нийт	736.8	217.5	44.1	998.2	15,789.7	6.3%

Эх сурвалж: ҮСХ-ны мэдээллийн сан (www.1212.mn)


Аймгуудаар тодруулбал, улсын хэмжээнд өргөст хэмх тариалсан 736.8 га талбайн 280.1 га буюу 38.0%-ийг Сэлэнгэ, 124.9 га буюу 17.0%-ийг Ховд, 117.1 га буюу 15.9%-ийг Дархан-Уул аймагт тариалжээ. Тэгвэл улаан лоолийн талбайн 24.3%-ийг Ховд, 15.0%-ийг Сэлэнгэ, 7.2%-ийг Дорнод, 7.1%-ийг Өмнөговь аймагт тариалжээ. Чинжүү тариалсан талбайн 35.0%-ийг Сэлэнгэ, 7.4%-ийг Дорнод, 7.0%-ийг Улаанбаатар, 6.9%-ийг Булган аймагт тус тус тариалсан байна.

Дээрх 3 төрлийн ногооны тариалсан талбайн мэдээллийг Хүснэгт 1-д мэдээлсэн иргэд, ААН-ийн тариалж буй хүлэмжийн талбайтай харьцуулъя. Аймаг, нийслэлийн ХХААГ-уудын ирүүлсэн мэдээллээр (Хүснэгт 1), 17 аймаг болон нийслэлд ашиглаж буй нийт хүлэмжийн талбай 1,608,214 метр квадрат болно. Харин ҮСХ-ны мэдээллээр (Хүснэгт 3), эдгээр 17 аймаг болон нийслэлийн улаан лооль, өргөст хэмх, чинжүү тариалж буй нийт талбай 761.3 га буюу 7,613,000 метр квадрат болно. Эдгээр дүнг харьцуулбал, аймаг, нийслэлийн ХХААГ-ын мэдээлсэн хүлэмжийн талбай нь ҮСХ-ны мэдээлэл дэх өргөст хэмх, улаан лооль, чинжүү тариалдаг талбайн дөнгөж 21.1%-тай тэнцэж байна. Эндээс үзэхэд, ҮСХ-ны өргөст хэмх, улаан лооль, чинжүү тариалах талбайн мэдээлэлд хүлэмжээс хэд дахин илүү задгай талбайн мэдээллийг хамруулсан байх талтай юм.

2.2. Дотоодын хүлэмжийн хүнсний ногооны нийлүүлэлт

Энэ судалгаанд улаан лооль, өргөст хэмх, чинжүү, навчит ногоо (салатны навч гэх мэт)-г хүлэмжид тариалдаг хүнсний ногоо гэж үзсэн. Зураг 1-д дотоодын хүлэмжийн ногооны ургацын мэдээллийг 2020-2023 оноор харуулав. Эндээс үзвэл, хүлэмжийн ногооны ургацын дийлэнхийг буюу 60% орчмыг өргөст хэмх бүрдүүлдэг бөгөөд ургацын хэмжээ нь сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэх хандлагатай байна. 2020 онд улсын хэмжээнд 6,054.4 тонн өргөст хэмх хурааж байсан бол 2023 онд энэ хэмжээ 8,499.0 тонн болж нэмэгджээ. Ер нь өргөст хэмхийн тариалалт өмнөх 10 гаруй жилийн тариалалтаас эрс нэмэгдээд байна. Тухайлбал, 2010-2014 онд жилд дунджаар 4,090 тонн өргөст хэмх хурааж байсан бол 2015-2019 онд 3,993 тонныг хурааж байжээ.

Зураг 1. Хүнсний нарийн ногооны нийт ургац, тонн



Эх сурвалж: ҮСХ-ны мэдээллийн сан (www.1212.mn)

Үүний дараах гол тариалдаг хүнсний нарийн ногоо нь улаан лооль боловч сүүлийн жилүүдэд тариалалт нь өсөөгүй байна. 2020 онд улсын хэмжээнд 2,308.2 тонн улаан лооль хурааж байсан бол 2023 онд энэ хэмжээ 2,157.0 тонн болж буурчээ. Ер нь сүүлийн 10 гаруй жилд улаан лоолийн тариалалт бараг өөрчлөгдөөгүй байна. 2010-2014 онд жилд дунджаар 2,181 тонн улаан лооль хурааж байсан бол 2015-2019 онд 1,991 тонныг хурааж байжээ.

Навчит ургамал буюу цэцэгт байцаа, брокколи, салатны навч, бууцай, юцай зэргийн ургац нь өргөст хэмх, улаан лоольтой харьцуулахад маш бага боловч сүүлийн жилүүдэд тариалалт нь эрс нэмэгдэх хандлагатай байна. Жишээлбэл, 2020 онд навчит ногооны ургац жилдээ 191.6 тонн байсан бол 2023 онд 684.7 тонн хүрсэн. Харин чинжүүний тариалалт өөрчлөгдөөгүй, жилдээ 300 тонн орчимд хэвээр байна.

Хүснэгт 4-д хүнсний ногооны ургацын мэдээллийг 2023 оны байдлаар аймгаар харьцуулан харуулав.

Хүснэгт 4. Хүнсний ногооны ургац, тонн, 2023 он

Аймаг, нийслэл	Өргөст хэмх	Улаан лооль	Чинжүү	Навчит ургамал	Хүлэмжийн ногооны нийт	Хүнсний ногоо - Бүгд
Архангай	5.2	3.7	1.1	0.2	10.1	882.9
Баянхонгор	38.3	43.6	3.4	1.3	86.6	916.0
Баян-Өлгий	118.0	64.2	0.0	1.5	183.7	1,555.6

Булган	47.3	21.8	4.5	19.5	93.1	2,426.3
Говь-Алтай	42.1	16.0	3.4	0.6	62.1	412.1
Говьсүмбэр	19.5	17.3	5.5	0.5	42.7	275.1
Дархан-Уул	1,763.8	30.4	11.5	50.2	1,855.9	25,636.3
Дорноговь	128.2	34.2	4.5	8.4	175.3	526.1
Дорнод	133.1	109.2	16.6	17.9	276.8	1,687.4
Дундговь	37.2	11.2	5.3	16.7	70.4	208.4
Завхан	29.7	6.7	2.2	6.9	45.5	1,326.0
Орхон	252.8	23.1	7.6	32.1	315.6	9,866.3
Өвөрхангай	79.3	78.8	14.1	8.9	181.1	2,817.0
Өмнөговь	77.9	219.9	7.1	0.6	305.5	670.5
Сүхбаатар	186.0	172.7	21.1	2.9	382.6	1,060.7
Сэлэнгэ	3,481.7	329.1	145.5	155.0	4,111.2	86,271.3
Төв	259.9	154.5	11.5	30.7	456.6	37,451.9
Увс	108.9	69.7	0.2	0.2	178.9	4,351.4
Ховд	822.9	383.4	3.8	0.0	1,210.1	17,994.1
Хөвсгөл	84.2	44.1	5.3	6.9	140.5	3,751.9
Хэнтий	92.5	49.0	5.9	2.0	149.4	3,476.3
Улаанбаатар	690.8	274.5	32.0	321.8	1,319.1	4,817.2
Нийт	8,499.0	2,157.0	312.0	684.7	11,652.6	208,380.6

Эх сурвалж: ҮСХ-ны мэдээллийн сан (www.1212.mn)

Сэлэнгэ аймаг нийт хүнсний ногооны ургацын адилаар нарийн ногооны ургацаар улсад тэргүүлж байна. Өргөст хэмхийн ургацын 3.5 мянган тонн буюу 41.0%-ийг Сэлэнгэд тариалсан бол үүний дараа 20.8%-ийг Дархан-Уул, 9.7%-ийг Ховд аймагт тариалжээ. Улаан лоолийн ургацын 383 тонн буюу 17.8%-ийг Ховд аймагт тариалсан бол 15.3%-ийг Сэлэнгэ, 12.7%-ийг Улаанбаатарт тариалжээ. Чинжүүний ургацын 146 тонн буюу 46.6%-ийг Сэлэнгэ аймагт тариалсан бол 10.3%-ийг Улаанбаатар, 5.3%-ийг Дорнод, 4.5%-ийг Өвөрхангай аймгуудад тариалсан байна. Навчит ургамлын ургацын 322 тонн буюу 47.0%-ийг Улаанбаатарт тариалсан бол 22.6%-ийг Сэлэнгэ, 7.3%-ийг Дархан-Уул аймагт тариалсан байна.

Энэ судалгаагаар, аймгуудын ХХААГ-аас хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн ургацын мэдээллийг цуглуулсан. Нийт 14 аймгийн хүлэмжийн ургацын мэдээлэл хүлээж авсныг Хүснэгт 5-д харуулав. Эдгээр аймгийн хүлэмжийн нийт ургац 2023 онд 2,909 тонн байна. Харин Хүснэгт 4 дэх ургацын мэдээллээс харьцуулагдах 14 аймгийн улаан лооль, өргөст хэмх, чинжүү, навчит ногооны нийт ургацын хэмжээг тооцоход 8,790 тонн болж байна. Өөрөөр хэлбэл, 14 аймгийн ХХААГ-ын ирүүлсэн хүлэмжийн ургацын нийт дүн нь ҮСХ-ны мэдээлэл дэх эдгээр аймгийн нарийн ногооны ургацын

дүнгийн 33.1%-тай тэнцүү байна. Ургацын мэдээллийн энэ зөрүү нь нарийн ногооны тариалсан талбайн мэдээллийн зөрүүтэй адилаар, их хэмжээний нарийн ногоог хүлэмжид биш задгай талбайд тариалсантай холбоотой байж болох юм.

Хүснэгт 5. Хүлэмжийн нарийн ногооны ургацын хэмжээ, тонн, 2023 он

№	Аймаг	Ургац, тн
1	Баянхонгор	54
2	Говь-Алтай	4
3	Говьсүмбэр	31
4	Дархан-Уул	172
5	Дундговь	101
6	Дорноговь	434
7	Дорнод	74
8	Завхан	165
9	Өвөрхангай	227
10	Сүхбаатар	359
11	Сэлэнгэ	447
12	Ховд	59
13	Хөвсгөл	96
14	Хэнтий	686
Нийт		2,909

Эх сурвалж: Аймгуудын ХХАА газруудын бэлтгэсэн статистик мэдээлэл


3. ИМПОРТЫН ӨРСӨЛДӨӨН



3.1. Хүлэмжийн ногооны импорт

Сонгосон дөрвөн төрлийн хүнсний ногооны импорт 2022 онд 9,304.6 тонн байсан бол 2023 онд 18,566.0 тонн болж 100% өссөн. Зураг 2-т харуулснаар, энэ өсөлт үндсэндээ навчит ногооны импорт 6,316 тонноос 15,690 тонн болж огцом нэмэгдсэнээс шалтгаалжээ. Мөн улаан лоолийн импорт 1,173.7 тонноос 1,558.2 тонн болж эрс нэмэгдсэн байна. Харин өргөст хэмх (1,514.4 тонноос 1,138.2 тонн), чинжүү (300.4 тонноос 179.6 тонн)-ний импорт буурчээ.


Зураг 2. Хүнсний ногооны импорт, тонн



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Зураг 3-т хүнсний ногооны импортыг мөнгөн дүнгээр харьцуулав. Сонгосон 4 төрлийн хүнсний ногоог 2022 онд 13.1 тэрбум төгрөг (~4.2 сая ам.доллар)-өөр импортолсон бол 2023 онд 16.8 тэрбум төгрөг (~4.8 сая ам.доллар)-өөр импортолжээ. Импортын мөнгөн дүн 28% (ам.доллороор бол 16%) өссөн.

Зураг 3. Хүнсний ногооны импорт, сая төгрөг²




Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

² Монголбанкны зарласан 2022 оны ам.долларын ханш 3,144.83 төгрөг, 2023 оны ханш 3,465.78 төгрөг.

Импортын хэмжээг улирлаар харьцуулбал, хүнсний нарийн ногооны импорт жил бүрийн I, IV улиралд нэмэгдэх хандлагатай байдаг бол III улиралд эрс буурдаг байна. Энэ нь эдгээр хүнсний ногооны дотоодын нийлүүлэлтийн мөчлөгтэй холбоотой юм.

Зураг 4. Хүнсний нарийн ногооны импорт, тонн, улирлаар



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2021 оны сүүл, 2022 оны эхээр улаан лооль, өргөст хэмхийн импорт эрс нэмэгдсэн нь COVID-19 цар тахлын үеийн хил гаалийн хязгаарлалт суларч, импорт сэргэсэнтэй холбоотой. Мөн хязгаарлалтын улмаас хоёр жил тэмдэглээгүй байсан шинэ жил, цагаан сарын баярыг айл өрх, албан байгууллагууд өргөн хүрээтэй тэмдэглэх хүлээлт үүссэн нь үүнд нөлөөлсөн болов уу. Учир нь түүний дараагийн жилүүдэд өвлийн улирлын импорт төдийлөн нэмэгдээгүй. Үүнээс гадна ялангуяа 2022 онд цар тахлын дараах үеийн тээвэр логистикийн саатал, Орос-Украины дайнаас шалтгаалсан хүнсний үнийн өсөлт дэлхий даяар өндөр байсан нь импорт буурахад нөлөөлсөн. 2023 оны сүүлийн улиралд улаан лооль, өргөст хэмхийн импорт улирлын хэлбэлзлийг даган өмнөх улирлуудаас эрс нэмэгджээ. Харин навчит ногооны хувьд импорт 2022 оны III улирлаас хойш жилийн бүх улиралд огцом нэмэгдсэн нь сонирхол татаж байна.

Дээрх хүнсний ногооны импортын биет хэмжээний мэдээллийг мөнгөн дүнгээр илэрхийлэн Зураг 5-д харуулав. Хүнсний ногооны импортын улирлаарх ерөнхий хандлага дээрх зурагтай адил байна. 2021 оны эцэс, 2022 оны эхэнд өргөст хэмх, улаан лоолийн импортод улиралд 2-2.5 тэрбум төгрөг зарцуулсан бол түүнээс хойш огцом буурчээ. Харин 2022 оны IV улирлаас хойш навчит ногооны импортод улирал бүр 3 тэрбум орчим төгрөг зарцуулдаг болжээ.

Зураг 5. Хүнсний нарийн ногооны импорт, сая төгрөг, улирлаар



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

3.2. Дотоодын тариалалт ба импортын харьцаа

Манай улсын нийт хүнсний ногооны дотоодын хэрэглээ 2021 оны байдлаар 197.8 мянган тонн бөгөөд үүний 131.5 мянган тонн буюу 66.5%-ийг дотоодын үйлдвэрлэлээс, 66.3 мянган тонн буюу 33.5%-ийг импортоор хангаж байв (Хөгжлийн шийдэл, 2023). Тэгвэл хүлэмжид тариалдаг хүнсний нарийн ногооны хувьд дотоодын тариалалт ба импортын харьцаа ногооны төрлүүдээр ямар байдаг вэ? Энэ зах зээл импортоос хэр хүчтэй хамаардаг вэ? Үүнд хариулахын тулд бид энэ тайлангийн 2-р бүлэгт танилцуулсан дотоодын хүлэмжийн аж ахуйгаас хураасан ургацын мэдээлэл ба өмнөх хэсэгт танилцуулсан импортын мэдээллийг ашиглав.

Хүнсний нарийн ногооны дотоодын тариалалт ба импортын хэмжээг Хүснэгт 6-д харьцуулан харуулав. Сонгосон 4 төрлийн хүнсний ногооны хангамжийг импортын ба дотоодын ургацын нийлбэрээр тодорхойлж нийт дүнгээр авч үзэхэд, навчит ногоо талаас илүү хувийг, үүний дараа өргөст хэмх, улаан лооль, хамгийн бага хэмжээг чинжүүний нийлүүлэлт эзэлж байна.


Хүснэгт 6. Хүнсний ногооны хангамж, импорт ба дотоодын тариалалт, тонн, 2023 он

	Импорт	Дотоодын тариалалт	Нийт
Улаан лооль	1,558	2,157	3,715
Өргөст хэмх	1,138	8,499	9,637
Чинжүү	180	312	492
Навчит ногоо	15,690	685	16,375
Нийт	18,566	11,653	30,219

Эх сурвалж: ҮСХ-ны мэдээлэлд үндэслэсэн судлаачдын тооцоо

Дээрх харьцааг хүнсний ногоо тус бүрийн хувьд нийт нийлүүлэлтэд эзлэх харьцаагаар Зураг 6-д харуулав. Эдгээр 4 нэр төрлийн ногооны импорт нийт нийлүүлэлтийн 60% эзэлдэг бол дотоодын тариалалтын хэмжээ 40%-ийг эзэлж байна. Өргөст хэмхийн хувьд импортын эзлэх хувь хамгийн бага буюу 12% байгаа бол чинжүүний импорт 37%, улаан лоолийн импорт 42% байна. Харин навчит ногооны хангамж бараг бүхэлдээ буюу 96% импортоос хамааралтай байна.

Зураг 6. Хүлэмжийн ногооны дотоодын тариалалт ба импортын эзлэх хувь, 2023 он



Эх сурвалж: ҮСХ болон ГЕГ-ын статистик мэдээлэлд үндэслэсэн судлаачийн тооцоо

Гэхдээ дээрх тооцоонд импортоор орж ирж, дотоодын тариаланчид, үйлдвэрлэгчидтэй өрсөлдөж буй лаазалсан, хөлдөөсөн ногоог оруулаагүй байгааг тэмдэглэх нь зүйтэй. Гаалийн нээлттэй мэдээлэлд лаазалсан улаан лоолийн импортын мэдээлэл байдаг боловч бусад ногоо болох лаазалсан өргөст хэмх, чинжүү, навчит ногоог онцолж ялгалгүй, лаазалсан ногоо, жимс, самар, лаазалсан буюу хөлдөөсөн бусад ногоо, лаазалсан буюу хөлдөөгөөгүй бусад ногоо гэсэн ангилалд бүртгэсэн байдаг. Хэрвээ эдгээр хагас боловсруулсан бүтээгдэхүүний импортыг харгалзаж үзвэл дээр дурдсан импортын эзлэх хувиуд улам нэмэгдэнэ.

Эндээс харахад, навчит ногоо, улаан лооль зэрэг ногооны тариалалтыг нэмэгдүүлж, импортын эзлэх хувийг бууруулах орон зай их байна.

4. ХҮЛЭМЖИЙН НОГООНЫ ДОТООДЫН ЭРЭЛТ




4.1. Айл өрхүүдийн хүлэмжийн ногооны хэрэглээ

ҮСХ-ны 2021-2023 оны Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)-ны мэдээллээс тооцоход³, Монголын нийт өрх жилд 1,000 тонн орчим улаан лооль, 2,000 тонн орчим өргөст хэмх хэрэглэсэн бөгөөд хэрэглээ нь 5-7% өсжээ. Харин навчит ургамал (салатны навч, цэцэгт байцаа, яншуй, бууцай гэх мэт), чинжүүний хэрэглээ хэлбэлзэл ихтэй байжээ. Тухайлбал, навчит ургамлын хэрэглээ 2,284 тонноос 1,649 тонн, чинжүүний хэрэглээ 1,896 тонноос 1,378 тонн болж тус тус эрс буурсан байна. Мөн савласан салат, савласан өргөст хэмхийн хэрэглээ 2,123 тонноос 1,946 тонн болж буурчээ.

Өрхүүд өргөст хэмхийг улаан лоолиос 2 дахин их хэмжээтэй хэрэглэдэг байна. Гэхдээ эдгээр нарийн ногооны нийт хэрэглээ маш бага байгаа юм. Тухайлбал, ӨНЭЗС-аас тооцсон төмс, лууван, байцаа, сонгино гэх мэт бусад хүнсний ногооны өрхүүдийн нийт хэрэглээ 2021 онд 121 мянган тонн, 2022 онд 119 мянган тонн байгаа бол энд авч үзэж буй нарийн ногооны жилийн нийт хэрэглээ 8 - 9 мянган тонн л байна.

Зураг 7. Нийт өрхүүдийн нарийн ногооны жилийн хэрэглээ, тонн



Эх сурвалж: ҮСХ-ны ӨНЭЗС-ны өгөгдөлд үндэслэсэн судлаачдын тооцоолол


2021 онд өрхүүд улаан лооль, өргөст хэмхийн хэрэглээний 94%-ийг худалдан авч хангаж байсан бол 2022 онд 91%-ийг худалдан авчээ. Харин навчит ургамлын хувьд 2021 онд 99%, 2022 онд 96%-ийг, чинжүүний хувьд 2021 онд 100%, 2022 онд 99%-ийг худалдан авчээ. Өрхүүд хүлэмжид тариалдаг ногооны үлдсэн багахан хэрэглээг өөрсдийн тариалангаас хангажээ.

Өрхүүдийн хүлэмжийн ногооны нийт худалдан авалтыг Зураг 8-д харуулав.

³ 2021, 2022 онд ҮСХ-ны ӨНЭЗС-д оролцсон өрхүүдийн мэдээллээс нийт улсын хэмжээн дэх өрхүүдийн хэрэглээг тооцохдоо уг түүвэр судалгааны өрхийн жинг ашиглав. Өөрөөр хэлбэл, энэ бүлэгт танилцуулах үр дүнгүүд нь 2021 оны 920.2 мянган өрх, 2022 оны 941.5 мянган өрхийг төлөөлөх юм.

Эдгээр нарийн ногоог худалдан авахад өрхүүд 2021 онд нийт 60.3 тэрбум төгрөг, 2022 онд нийт 68.9 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Бусад хүнсний ногоонд өрхүүд 2021 онд 203.8 тэрбум төгрөг, 2022 онд 280.5 тэрбум төгрөг зарцуулжээ. Эндээс үзвэл, хүнсний нарийн ногоонд өрхүүд 2021 онд нийт хүнсний ногооны зардлынхаа 22.8%-ийг, 2022 онд 19.7%-ийг зарцуулжээ.

Зураг 8. Нийт өрхүүдийн нарийн ногооны жилийн хэрэглээний дүн, тэрбум төг




Эх сурвалж: ҮСХ-ны ӨНЭЗС-ны өгөгдөлд үндэслэсэн судлаачдын тооцоолол

Нэр төрлөөр авч үзвэл, улаан лооль худалдан авсан зардал 2022 онд өмнөх оноос 43% өссөн бол өргөст хэмхийн зардал 23%, чинжүүний зардал 3%, савласан өргөст хэмх болон салатны зардал 23% өсжээ. Харин навчит ургамал авах зардал 3% буурсан байна.

Зураг 7-д харуулсан хүнсний ногооны хэрэглээний тоо хэмжээний өөрчлөлтийг харгалзан үзвэл, худалдан авсан зардал ихээр өссөн нь эдгээр ногооны үнэ 2022 онд ихээхэн нэмэгдсэнийг илтгэж байна. Ялангуяа навчит ургамал, чинжүү, савласан өргөст хэмх ба салатны үнэ их өсөхөд өрхүүд худалдан авах тоо хэмжээгээ бууруулж, зардлын өсөлтөө бага байлгахыг оролджээ.

Зураг 9. Өрхийн нарийн ногооны сарын хэрэглээ (кг), улирлаар




Эх сурвалж: ҮСХ-ны ӨНЭЗС-ны өгөгдөлд үндэслэсэн судлаачдын тооцоолол

Өрхийн хэрэглэж буй хүнсний нарийн ногоо буюу навчит ургамал, улаан лооль, өргөст хэмх, чинжүү, савласан өргөст хэмх болон салатны сарын хэрэглээг харвал, өрхүүд эдгээр ногоог сард дунджаар дөнгөж 100-300 граммыг хэрэглэж байна. Гэхдээ зарим ногооны хувьд улирлаас хамаарсан хэлбэлзэл их ажиглагдаж байна (Зураг 9). Тухайлбал, улаан лооль, өргөст хэмхийн хэрэглээ жил бүрийн III улиралд хамгийн дээд цэгтээ хүрдэг бол IV улиралд хамгийн бага цэгтээ хүрдэг байна.

Хүнсний ногооны хэрэглээний улирлын хэлбэлзэл ерөнхийдөө эдгээр ногооны нийлүүлэлт болон үнэтэй ихээхэн хамааралтай. Зураг 10-аас харахад жил бүрийн III улиралд улаан лооль, өргөст хэмх, навчит ногооны үнэ хамгийн бага түвшиндээ хүрдэг бол түүнээс хойш IV улирал болон дараа оны I улиралд үнэ эрс өсдөг байна.

Зураг 10. Хүнсний ногооны үнэ (төгрөг / кг), улирлаар



Эх сурвалж: ҮСХ-ны ӨНЭЗС-ны өгөгдөлд үндэслэсэн судлаачдын тооцоолол

Мөн дээрх зургаас бүх төрлийн ногооны үнэ 2022 онд өмнөх онтой харьцуулахад эрс нэмэгдсэн нь ажиглагдаж байна. Энэ нь КОВИД-19 цар тахлын үеийн хил гаалийн саатал үргэлжилж байснаас үүдэн импортын ногооны нийлүүлэлт саатсан, Орос-Украины дайн эхэлснээр ХАА-н салбарын тоног төхөөрөмж, үр, бордооны хангамж тасалдсан зэрэг хүчин зүйлстэй холбоотой юм.

Хүнсний ногооны эрэлт, тэр дундаа хүлэмжид тариалдаг нарийн ногооны эрэлт хэрэглээ өрхийн бүлгүүдээр маш их ялгаатай байдаг. Бид энд хүнсний нарийн ногооны зах зээлийн багтаамж, хэрэглээний ялгааг аймгаар болон өрхийн орлогын бүлгээр харьцуулж авч үзлээ.

Хүснэгт 7-д өрхүүдийн 2022 онд хэрэглэсэн хүнсний ногооны нийт хэрэглээг аймаг, нийслэлээр харьцуулан харуулав. Энд ҮСХ-ны ӨНЭЗС нь аймгийн түвшинд төлөөлөх чадвартай боловч хэрэглээ багатай зарим барааны

хэрэглээг бодит байдлаас зөрүүтэй тооцох магадлалтайг сануулах нь зүйтэй юм. Гэхдээ энэ хүснэгт дэх мэдээлэл нь аймгуудын хүнсний ногооны зах зээлийн багтаамжийн талаарх ерөнхий харьцааг хангалттай харуулна гэж үзэж байна.

Хүснэгт 7. Өрхүүдийн хүнсний ногооны нийт хэрэглээ (тонн), 2022 он, аймгаар

	Улаан лооль	Өргөст хэмх	Навчит ногоо	Чинжүү	Бусад ногоо
Архангай	1.5	15.9	5.7	5.6	2,865.8
Баян-Өлгий	6.8	20.1	0.5	4.2	3,350.7
Баянхонгор	1.0	1.1	5.2	9.6	2,774.1
Булган	2.3	26.9	4.2	4.2	2,265.5
Говь-Алтай	5.4	5.2	0.2	7.1	1,692.9
Дорноговь	17.6	62.2	13.8	31.7	3,130.5
Дорнод	22.9	41.5	11.3	33.8	3,325.1
Дундговь	6.1	5.0	6.3	6.2	1,677.3
Завхан	2.3	21.2	4.8	5.4	2,573.3
Өвөрхангай	6.5	27.4	2.9	33.4	3,247.9
Өмнөговь	47.8	88.8	14.4	185.1	3,855.8
Сүхбаатар	4.1	19.3	4.8	10.5	1,936.6
Сэлэнгэ	2.6	18.2	6.6	16.1	4,582.8
Төв	9.0	36.5	7.5	16.0	4,289.5
Увс	1.7	5.6	1.2	7.9	2,098.8
Ховд	44.6	27.3	0.6	12.3	3,002.0
Хөвсгөл	0.5	15.1	6.9	6.9	3,679.8
Хэнтий	7.4	35.6	4.8	15.8	2,567.4
Дархан-Уул	24.7	105.6	22.2	69	4,694.9
Орхон	53.3	154.1	77.6	68.4	3,865.1
Говьсүмбэр	8.3	16.1	8.0	11.1	967.9
Улаанбаатар	794.2	1,408.3	1,439.8	817.8	56,494.4
Нийт	1,070.6	2,157.0	1,649.3	1,378.1	118,938.1

Эх сурвалж: ҮСХ-ны ӨНЭЗС-ны өгөгдөлд үндэслэсэн судлаачдын тооцоолол

Хүснэгтээс харахад, улаан лооль, өргөст хэмх, навчит ногоо, чинжүү гэх мэт нарийн ногооны дийлэнхийг Улаанбаатар хотын өрхүүд хэрэглэжээ. Үүний дараа Орхон, Өмнөговь, Дархан-Уул, Дорнод, Дорноговь аймгийн хүн амын хэрэглээ бусдаасаа харьцангуй өндөр байна. Энэ нь хүн ам олонтой нийслэл болон томоохон хотууд, зах зээлд ойр, эсвэл ногоо тарьдаг өрх олонтой аймгууд нарийн ногооны хэрэглээ ихтэй байна. Харин газар тариалангийн гол

бүс нутаг болох Сэлэнгэ аймагт бусад хүнсний ногооны хэрэглээ их боловч нарийн ногооны хэрэглээ харьцангуй бага байдаг нь анхаарал татаж байна.

Хүснэгт 8-д хүнсний ногооны худалдан авалтыг мөнгөн дүнгээр илэрхийлж, зах зээлийн нийт багтаамжийг аймгуудаар харьцуулан харуулав. Энэ нь өмнөх хүснэгт дэх хүнсний ногооны хэрэглээний хэмжээтэй шууд хамааралтай байна. Тухайлбал, нийслэл хотод хүнсний ногооны борлуулалтын дийлэнх хийгджээ. 2022 онд улсын хэмжээнд өрхүүд нийт 9.8 тэрбум төгрөгийн улаан лооль худалдан авснаас нийслэлийн өрхүүд 8.0 тэрбум төгрөгийг, 15.8 тэрбум төгрөгийн өргөст хэмхийн 11.5 тэрбумыг, 16.0 тэрбум төгрөгийн навчит ногооны 14.2 тэрбумыг, 11.6 тэрбум төгрөгийн чинжүүний 7.2 тэрбумыг, 15.6 тэрбумын савласан өргөст хэмх болон салатны 10.0 тэрбумыг нийслэлийн өрхүүд зарцуулжээ.

Хүснэгт 8. Өрхүүдийн хүнсний ногооны жилийн худалдан авалт (сая төгрөг), 2022 он, аймгаар

	Улаан лооль	Өргөст хэмх	Навчит ногоо	Чинжүү	Савласан өргөст хэмх, салат	Бусад ногоо
Архангай	15.1	106.1	23.7	39.9	256.5	6,747.6
Баян-Өлгий	53.0	101.0	2.5	21.2	321.1	6,019.8
Баянхонгор	7.2	8.3	42.6	78.1	182.0	6,734.9
Булган	19.2	101.3	25.3	26.9	71.1	4,548.5
Говь-Алтай	25.0	41.2	2.1	43.5	66.4	3,692.2
Дорноговь	74.4	314.4	114.6	205.9	503.6	7,501.7
Дорнод	98.6	134.0	94.8	308.8	362.6	7,194.6
Дундговь	46.0	25.0	43.0	45.7	77.9	3,950.2
Завхан	24.5	180.8	38.8	45.9	523.9	6,000.7
Өвөрхангай	49.4	154.9	17.9	274.8	76.1	7,112.4
Өмнөговь	278.4	497.7	143.1	1,468.9	353.3	10,379.0
Сүхбаатар	34.4	122.8	47.2	91.3	517.8	4,680.4
Сэлэнгэ	23.4	67.1	32.6	140.1	111.4	9,148.0
Төв	75.5	244.9	72.2	118.3	335.4	8,178.2
Увс	10.7	34.1	11.1	49.2	123.6	5,188.1
Ховд	193.1	159.1	0.9	115.7	156.9	5,931.5
Хөвсгөл	5.3	112.3	93.2	49.1	105.5	8,256.2
Хэнтий	37.6	128.3	30.1	119.9	123.3	6,326.5
Дархан-Уул	174.7	628.6	257.3	496.9	113.9	11,479.0
Орхон	494.7	1,128.6	679.1	588.0	979.0	9,403.2
Говьсүмбэр	57.6	103.8	72.0	97.3	167.9	2,154.6
Улаанбаатар	8,013.6	11,457.7	14,178.7	7,200.7	10,056.4	139,851.1

Нийт	9,811.4	15,852.0	16,022.8	11,626.1	15,585.6	280,478.4
------	---------	----------	----------	----------	----------	-----------

Эх сурвалж: ҮСХ-ны ӨНЭЗС-ны өгөгдөлд үндэслэсэн судлаачдын тооцоолол

Хот, суурин газрын өрхүүд өрхийн орлогын түвшин өндөртэй учраас үнэтэй нарийн ногоог илүү хэрэглэдэг байж болох юм. Үүнийг тодруулан, Хүснэгт 9-д өрхүүдийн хүлэмжийн ногооны дундаж хэрэглээг өрхийн орлогын бүлгүүдээр харьцуулан харуулав. Энд нийт өрхүүдийг орлогын түвшнээр нь тэнцүү 5 бүлэгт хувааж, бүлэг тус бүрийн өрхийн сарын дундаж худалдан авалтын хэмжээг мөнгөн дүнгээр илэрхийлэв. Хүснэгтээс харахад, өрхийн орлого өндөр байх тусам хүнсний ногоо худалдан авахад зарцуулах мөнгө илүү байна. Тэр дундаа нарийн ногооны зардал орлогын түвшнээс бүр ч илүү хүчтэй хамаарч байна. Аль аль бүлгийн өрхүүд дунд эдгээр нарийн ногоог худалдан авдаггүй өрх маш олон байгаа боловч өрхийн орлого нэмэгдэхийн хэрээр нарийн ногоо худалдан авах хандлага нь нэмэгддэг байна.

Хүснэгт 9. Өрхүүдийн хүнсний ногооны сарын дундаж худалдан авалт (төгрөг), 2022 он, орлогын бүлгээр

	Улаан лооль	Өргөст хэмх	Навчит ногоо	Чинжүү	Савласан өргөст хэмх, салат	Бусад ногоо
Ядуу	166	338	403	353	439	15,801
Дундаас доогуур	347	627	782	667	803	21,331
Дундаж	593	1,059	982	923	1,161	24,924
Дундаас дээгүүр	803	1,489	1,692	1,195	1,563	28,708
Чинээлэг	2,430	3,499	3,233	2,007	2,932	33,366

Эх сурвалж: ҮСХ-ны ӨНЭЗС-ны өгөгдөлд үндэслэсэн судлаачдын тооцоолол

Жишээлбэл, улаан лооль худалдан авахад хамгийн бага орлоготой ядуу 20%-ийн өрхүүд нь сард дунджаар дөнгөж 166 төгрөг зарцуулж байгаа бол хамгийн чинээлэг 20%-ийн өрхүүд 2,430 төгрөг зарцуулж байна. Өргөст хэмхийн хувьд энэ харьцаа 338 төгрөг ба 3,499 төгрөг, навчит ногооны хувьд 403 төгрөг ба 3,233 төгрөг, чинжүүний хувьд 353 төгрөг ба 2,007 төгрөг, савласан өргөст хэмх, салатны хувьд 439 төгрөг ба 2,932 гэсэн харьцаатай байна. Харин бусад ногооны хувьд ядуу ба чинээлэг өрхүүдийн зардлын харьцаа нь 15,801 төгрөг ба 33,366 төгрөг буюу нэлээд ойрхон байдаг ажээ.

4.2. Нийтийн хоолны үйлдвэрлэл дэх хүлэмжийн ногооны эрэлт

Хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээнд чухал байр суурь эзэлдэг оролцогчид бол нийтийн хоолны газрууд юм. Гэвч энэ салбарын хүнсний нарийн ногооны хэрэглээний талаар улсын хэмжээнд нэгдсэн статистик мэдээлэл одоогоор байхгүй байна. Иймээс энэ судалгаанд хүнсний сүлжээ ресторан, томоохон

албан байгууллага, сургууль, цэцэрлэгийн хоолны газар, хүнсний ногооны захуудын төлөөлөл болох цөөн аж ахуйн нэгжтэй ярилцлага хийж, тэдний хүлэмжийн ногооны эрэлтийн талаар зарим мэдээллийг тодруулав.

Судалгаанд хамрагдсан том ресторан буюу сүлжээ хоолны газар, том үйлдвэр, групп компанийн хоолны газрууд долоо хоногт дунджаар 1 тн орчим нарийн ногоо хэрэглэдэг бол жижиг хоолны газрууд долоо хоногт дунджаар 80 кг орчим нарийн ногоо хэрэглэдэг байна. Гэхдээ энэ нь зөвхөн судалгаанд хамрагдсан цөөн аж ахуйн нэгжийн дундаж болохыг дурдах нь зүйтэй.

Хүснэгт 10. Зарим хоолны газрын хүнсний ногооны 7 хоногийн дундаж хэрэглээ, кг

	Том ресторан	Жижиг хоолны газар
Өргөст хэмх	425	21
Улаан лооль	350	22
Навчит ногоо	180	17
Чинжүү	60	19
НИЙТ	1,015	79

Эх сурвалж: Нийтийн хоолны салбарын ААН-үүдтэй хийсэн ярилцлага

Ресторан, хоолны газрууд хүнсний ногоог ихэвчлэн хүнсний зах, бөөний төвүүдээс худалдан авч байна. Хөдөө орон нутгийн томоохон ресторанууд импортын хүнсний ногоог Улаанбаатар дахь “Барс” зэрэг захуудаас захиалж хүргүүлдэг, эсвэл өөрсдөө худалдан авдаг. Томоохон ресторанууд хүнсний ногооны тариалагчидтай, эсвэл зуучлагч компаниудтай шууд гэрээ байгуулж хамтран ажиллах тохиолдол элбэг байна. Мөн ихэнх ресторануудад хүнсний ногоог хүргэж өгдөг борлуулагчид байдаг ажээ.

Ресторан том жижиг ААН-д хэрэгцээт нарийн ногоог хүргэж өгдөг борлуулагч байгууллага хувь хүмүүс нь худалдаалах хэрэгцээт ногоог 7 хоногт нэг удаа импортоор оруулж ирдэг. Импортлогчид бөөний худалдаачид нарийн ногоог удаан хадгалбал ногооны чанар муудах эрсдэлтэй, агуулахын багтаамж хангалтгүй учир хүнсний нарийн ногоог аль болох хурдан борлуулах, томоохон ресторануудад хүргэхэд анхаардаг.

Нийтийн хоолны газрууд дотоодын нарийн ногоо хэрэглэх сонирхолтой боловч дотоодын нийлүүлэлт жилийн 7-8-р сард л огцом нэмэгддэг, өвөл, хаварт дотоодын нийлүүлэлт ихээр тасалдаж үнэ нь өсдөг асуудлыг дурдаж байв. Иймээс, хүнсний ногооны худалдаа эрхлэгчид импортын ногооны борлуулалтыг голлон эрхэлдэг байна.

Судалгаанд оролцсон ресторанууд хэрэгцээт хүнсний ногоог тариаланчаас шууд худалдан авахдаа дараах хэлбэрүүдээр хамтран ажиллаж байна. Үүнд:

- Тариаланчид дээр очиж үнээ тохиролцон чанарыг нь шалгаж авдаг. Ингэхдээ ямар нэг гэрээ хийдэггүй.

- Эсвэл гэрээ байгуулж хамтран ажилладаг. Гэрээний дагуу хүнсний ногоог урьдчилан авдаг, тооцоог сарын сүүлд хийдэг. Буцаалт хийх боломжтой, ногоог нийлүүлэгч тал хүргэж ирдэг. Ингэхдээ чанар, хэмжээгээр ялгасан байдаг.
- Мөн удаан хугацаанд нэг тариаланчтай хамтран ажиллаж, хүнсний ногоо худалдан авдаг тохиолдлууд байна.
- Өөрсдөө тариалан эрхэлдэг компаниудтай хамтран ажилладаг.

Хүнсний ногоог тариаланчаас шууд худалдан авах хүсэлтэй ресторанууд тариаланчдад дараах шаардлагуудыг тавьдаг болохыг анхаарах нь зүйтэй. Үүнд:

- Шинэ, эрүүл, чанараа алдаагүй байх
- Найдвартай цаг хугацаандаа тогтмол нийлүүлэлт хийдэг байх
- Үнэ нь улирлаас хамааран хэлбэлздэггүй, тогтмол байх
- Хүргэлттэй байх
- Хадгалалтын горим зөрчөөгүй, зөв хадгалсан байх
- Үнэ боломжийн хямд
- Буцаалт хийх боломжтой
- Гарал үүсэл тодорхой
- Санхүүгийн баримт өгдөг байх
- Ногооны хэмжээ жигд, стандартад нийцсэн том байх гэх мэт


5. ХҮЛЭМЖИЙН НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ БА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА



5.1. Хүнсний нарийн ногооны хэрэглээ ба нийлүүлэлт

Өмнөх бүлгүүдэд танилцуулсан хүнсний нарийн ногооны нийлүүлэлт ба хэрэглээний мэдээллээс бид дотоодын зах зээл дээрх харьцааг дараах байдлаар (Зураг 11) илэрхийлж болох юм. Энд хүнсний ногооны эрэлт, нийлүүлэлтийн аль алины мэдээлэл байгаа 2022 оны байдлаар харуулав. 2022 онд улсын хэмжээнд 19.4 мянган тн. хүнсний нарийн ногоо нийлүүлсний талаас илүүг буюу 10.1 мянган тн-ыг дотоодын тариалалтаас хангасан бол 9.3 мянган тн-ыг импортоор хангажээ. Энэ нийлүүлсэн ногооны 8.2 мянган тн-ыг өрхүүд шууд боловсруулаагүй ногоо хэлбэрээр худалдан авч хүнсэндээ хэрэглэжээ. Харин үлдсэн 11.2 мянган тн ногоо нь нийтийн хоолны салбарын үйлдвэрлэл, лаазалж савласан салат гэх мэт эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашиглагджээ. Эндээс мөн тодорхой хувь нь хураалтын дараах хорогдол болжээ.

Зураг 11. Хүнсний нийт нарийн ногооны нийлүүлэлт ба хэрэглээний харьцаа, 2022 он




Эх сурвалж: ГЕГ-ын статистик, ҮСХ-ны газар тариалангийн салбарын статистик ба ӨНЭЗС-ны өгөгдөлд үндэслэсэн судлаачдын тооцоолол

Дээрх харьцааг нарийн ногооны төрлүүдээр ойролцоогоор тооцож болно. Зураг 12-т улаан лооль, өргөст хэмх, навчит ургамлын нийлүүлэлт ба хэрэглээний харьцаа, бүтцийг харуулав.

Харин энэ тооцоог чинжүүний хувьд хийхэд тоон мэдээллүүд нийцгүй байсан. Өрхүүдийн чинжүүний хэрэглээ нийт нийлүүлэлтээс ихээхэн давсан мэдээлэл гарсан тул чинжүүний импортын мэдээллийг нягтлах шаардлагатай юм.

Зураг 12. Хүнсний ногооны нийлүүлэлт ба хэрэглээний харьцаа, 2022 он, ногооны төрлөөр



Эх сурвалж: ГЕГ-ын статистик, ҮСХ-ны газар тариалангийн салбарын статистик ба ӨНЭЗС-ны өгөгдөлд үндэслэсэн судлаачдын тооцоолол

Зах зээл дээрх эрэлт, нийлүүлэлтийн харьцаа хэрхэн өөрчлөгдөж байгааг үнийн хөдөлгөөнөөс харж болдог. Сүүлийн жилүүдэд хүнсний нарийн ногооны дотоодын зах зээл дээрх илүүдэл, хомсдол хэр байсныг дараах хэсэгт үнийн шинжилгээгээр тодруулав.

5.2. Үнийн шинжилгээ

5.2.1. Үйлдвэрлэгчийн үнэ, үйлдвэрлэгчийн нэмэгдэл өртөг

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын (FAO) статистик мэдээллийн санд манай улсын газар тариалангийн үйлдвэрлэгчийн үнийг жилээр, хүнсний ногоо бүрээр нэгтгэн танилцуулдаг. Гэхдээ энэ нь газар тариалан эрхлэгч өрхүүдийн түүвэр судалгаанаас тооцсон үнээс ихээхэн зөрүүтэй байдаг тул энэ судалгаанд бид уг статистик мэдээллийн оронд ҮСХ-ны түүвэр судалгаанууд болон бусад судалгааны мэдээллийг голчлон ашиглалаа.

Бид энэ судалгаанд 2021-2023 оны ҮСХ-ны ӨНЭЗС-д хамрагдсан газар тариалан эрхлэгч өрхүүдээс улаан лооль тарьж борлуулсан 65 өрх, өргөст хэмх тарьж борлуулсан 103 өрхийн мэдээллийг ашиглаж, тухайн жилийн үйлдвэрлэгчийн голч (медиан) үнийг тооцон дараах хүснэгтэд харуулав. Бидний сонирхож буй чинжүү, навчит ногооны мэдээллийг ӨНЭЗС-нд нарийвчилж хамруулаагүй тул эдгээр ногооны үнийн талаар энэ хүснэгтэд оруулаагүй.

Хүснэгт 11. Хүнсний ногооны үйлдвэрлэгчийн голч (медиан) үнэ, төгрөг/кг

	2021 он	2022 он	2023 он
Улаан лооль	4,000	5,000	5,000
Өргөст хэмх	2,000	3,500	5,000

Эх сурвалж: ҮСХ-ны ӨНЭЗС-ны тариалан эрхлэгчдийн өгөгдлөөс тооцов


Үйлдвэрлэгчийн үнэтэй холбоотой нэг чухал асуудал нь энэ үнэд завсрын хэрэглээ болон нэмэгдэл өртгийн харьцаа хэр байгааг тооцох явдал юм. ҮСХ-ны 2015 оны хөдөө аж ахуйн дэлгэрэнгүй түүвэр судалгаагаар, газар

тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нэмэгдэл өртөг 50.9%-тай тэнцэж байжээ (ҮСХ, 2016). Гэхдээ энэ тооцоонд үр тариа, тэжээлийн ургамал тариалдаг өрхүүдийг хүнсний ногоо тарьдаг өрхүүдтэй хамтатгаж тооцжээ.

Харин энэ удаагийн судалгаанд хүлэмжийн аж ахуйн нэмэгдэл өртгийг тооцохын тулд дээрхтэй төстэй аргачлалаар, 2022 оны ҮСХ-ны ӨНЭЗС-ны мэдээллээс зөвхөн хүлэмжид өргөст хэмх, улаан лооль тариалдаг цөөн өрхийг ялган авч үзэв. Эдгээр цөөн өрхийн хувьд 2022 оны хүлэмжийн аж ахуйн жилийн борлуулалтын орлого нь дунджаар 1,030,000 төгрөг байсан бол зарлага нь 614,450 төгрөг байжээ.

Үүнээс, өрхийн тариаланчдын хүнсний ногоо тариалахтай холбоотой зардлын бүтцийг Зураг 13-д харуулав. Хүнсний ногоо тариалах зардалд бордоо (25.7%), үр (23.7%), шатахуун бусад түүхий эд (23.8%), цалин хөлс (13.0%) дийлэнхийг эзэлж байна. Судалгаанд хамрагдсан тариаланчдын хувьд татвар хураамж болон шавж устгалд зардал гаргаагүй гэж мэдээлжээ.

Зураг 13. Өрхийн аж ахуйд хүнсний ногоо тариалах зардлын бүтэц, 2022 он



Эх сурвалж: ҮСХ-ны ӨНЭЗС 2022 болон судалгааны багийн тооцоолол

Дээрх зардлуудаас цалин хөлс, татвар хураамж нь хүнсний ногоо тариалагчдын нэмэгдэл өртөгт тооцогдоно. Мөн өрхийн газар тариалангийн үйлдвэрлэлийн ашиг/алдагдлыг нэмэгдэл өртөгт тооцно. Нийлбэр дүнгээр, 2022 онд хүнсний ногоо тариалагч өрхүүдийн завсрын хэрэглээ нь 51.9% болсон. Үлдэх 48.1% нь үйлдвэрлэлийн нэмэгдэл өртөг бөгөөд үүнээс 7.8%-ийг цалин, 40.3%-ийг тариаланчдын ашиг бүрдүүлж байна.

Хэдийгээр дээрх түүвэр судалгаанууд үндэсний хэмжээний судалгаа боловч нэмэгдэл өртгийн тооцоог өрхийн нийт үйлдвэрлэлийн хувьд авч үзсэн бөгөөд хүнсний ногоо тус бүрээр нэмэгдэл өртгийн талаар нарийвчлан тооцох боломжгүй юм. Хүнсний ногоо тус бүрийн нэмэгдэл өртгийг улсын

хэмжээнд тооцсон, сүүлийн үеийн, нээлттэй судалгаа ховор байна. Зарим бүс нутгийг сонгож хийсэн судалгааны үр дүнг SECiM төслийн хүрээнд 2018 онд хийгдсэн “Монгол Улсын ХАА-н гаралтай бүтээгдэхүүний экспорт, импорт: үнэ цэний сүлжээтэй уялдах нь” судалгааны тайланд танилцуулсан байдаг (SECiM, 2018). Гэхдээ энд улаан лооль, өргөст хэмх зэрэг нарийн ногооны өртгийн шинжилгээг хамраагүй юм.

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2019 онд гүйцэтгэсэн чанарын судалгаанд нарийн ногоо тариалдаг өрхүүдээс зарим мэдээллийг тодруулжээ (ЭЗСЭШХ, 2019). Уг чанарын судалгаанд Сэлэнгэ аймгийн Мандал, Булган аймгийн Сэлэнгэ сумын тариаланчдыг хамруулжээ. Сонгосон тариаланчид орон нутагтаа 4-26 жил буюу дунджаар 18 жил ногоо тарьсан туршлагатай, 1-7 га буюу дунджаар 2.8 га газарт хүнсний ногоо тариалдаг тариаланчид байсан. Уг газар дээрээ зуны улиралд гэр бүлийн гишүүдээсээ гадна дунджаар 3 хүн, намар 12 хүн, хавар 5 хүн ажиллуулдаг ажээ. Эдгээр тариаланчдын хүлэмж ашиглалтын талаар өгсөн мэдээллийг Хүснэгт 12-т харуулав.

Хүснэгт 12. Хүлэмж, агуулах ашиглалт

Судалгаанд хамрагдсан нийт тариаланчийн тоо	11
Хүлэмжтэй тариаланчийн тоо	Нийт 9. Үүнээс давхардсан тоогоор энгийн хүлэмжтэй 7, хагас тоноглосон хүлэмжтэй 3
Хүлэмжийн талбай	Хамгийн бага – 12 м.кв Хамгийн том – 3760 м.кв Дунджаар – 680 м.кв
